

Сангийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ
БИЧИГ

Сангийн сайдын 2022 оны 135 дугаар тушаалаар оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусгасан.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

[2025 оны 01 дугаар сарын 16-ны өдөр]

Огноо:

Тендер шалгаруулалтын нэр: ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГТ ХООЛ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

Тендер шалгаруулалтын [ДГАСШСЦ1 202501001]
дугаар:

[ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ] нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг [ХООЛ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ]-ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

- Багц-1 Мах махан бүтээгдэхүүн
- Багц-2 Сүү сүүн бүтээгдэхүүн
- Багц-3 Хүнсний ногоо, жимс жимсгэнэ
- Багц-4 Бусад

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш [7] ба түүнээс дээш хоногийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

Тендерийг [2025 оны 01-р сарын 16 -ны 15:00 минут]—аас өмнө тендерийн баримт бичигт заасан журмаар ирүүлэх ба тендер нээлтийг [2025 оны 01 дугаар сарын 24]-ний өдрийн, [16:00 минут] -т зохион байгуулна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

[Сайншанд сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 1 давхарт ЗАН өрөөнд

Утас: 99288078

II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Дорноговь аймаг Сайншанд сумын хүүхдийн 1-р цэцэрлэг
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ДГАСШСЦ1 /202501001\
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц-1 Мах махан бүтээгдэхүүн Багц-2 Сүү сүүн бүтээгдэхүүн Багц-3 Хүнсний ногоо, жимс жимсгэнэ Багц-4 Бусад
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бичих: Багц-1 Мах махан бүтээгдэхүүн Багц-2 Сүү сүүн бүтээгдэхүүн
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсөөв
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 48,315.000 Багц №01: Мах, махан бүтээгдэхүүн- 12,350,000 Багц-№02: Сүү сүүн бүтээгдэхүүн-10,360,000 Багц-№03: Хүнсний ногоо-9,400,000 Багц-№04: Жимс, жимсгэнэ-3,755,000 Багц-№05: Бусад Хүнс -12,450,000
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
ТШЗ 9.2	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Дорноговь аймаг Сайншанд сумын Хүүхдийн 1-р дүгээр цэцэрлэг Хүлээн авагчийн нэр: Сайншанд сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг Дэнж 117 Хүүхдийн 1-р дүгээр цэцэрлэг Утасны дугаар: 99288078 Цахим шуудангийн хаяг: sodoo.jalkhaa@gmail.
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	

ТШЗ 12.2	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл байна.
ТШЗ 16.2	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: Шаардана:</p> <p>Санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх: 2023 он</p> <p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> - Батлагдсан маягтын дагуу үнийн санал ирүүлэх - Оролцогч компанийн танилцуулга дэлгэрэнгүй ирүүлэх /холбоо барих утас, хаяг, цахим шуудангийн хаяг ирүүлэх/ - Харилцагч банкны тодорхойлолт /хугацаа хэтэрсэн өр, зээлийн үлдэгдэлгүй байх - Гэрээний тусгай, ерөнхий нөхцлийг зөвшөөрсөн эсэх мэдүүлэг заавал ирүүлэх шаардлагатай - Тендерт оролцогч нь тендерт шалгарсан тохиолдолд үнийн дүн нь өөрчлөгдөхгүй тогтвортой байх - Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ - Нийгмийн даатгалын тодорхойлолт - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт - Тухайн бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэхэд хүнсний үйдвэрлэл үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй аймгийн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт - Нэгж бүтээгдэхүүний үндсэн шимт бодис тооцсон мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт /Энэ заалт 4,6-р багцад хамаарна/
ТШЗ 16.2.4	<p>Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: Шаардана:</p> <p>-Санхүүгийн тайланг ирүүлэх: 2023 он\</p> <p>-Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр төлбөргүй талаарх тодорхойлолт ирүүлнэ.</p>
ТШЗ 16.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа:
	<ul style="list-style-type: none"> • 2023 он
ТШЗ 16.6	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:
	<ul style="list-style-type: none"> - 2023 оны ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний туршлага - Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл - Нэмэлт шаардлага, шалгуур үзүүлэлт:...]
ТШЗ 16.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Шаардана
ТШЗ 16.6.2	Барааг өөрөө үйлдвэрлээгүй бол барааг нийлүүлэх боломжтой болохыг нотлох баримт: Шаардахгүй
ТШЗ 16.6.3	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: Шаардана.

	<p>Тухайн бараа нийлүүлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилчдын мэргэжлийн бэлтгэл, туршлагыг захиалагчаас тогтоосноор дараах хүснэгтээр ирүүлнэ. Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>Албан тушаал</th><th>Мэргэжил боловсрол</th><th>Хүний тоо</th><th>Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо</th><th>НД-ийн дэвтэрийн дугаар</th></tr> </thead> <tbody> <tr> <td colspan="5">1,2-р багцад шаардлагатай мэргэжлийн ажилтан</td></tr> <tr> <td>Хүнсний технологич /гэрээгээр ажилладаг байж болно/</td><td>1</td><td>1</td><td>2</td><td></td></tr> <tr> <td>Түгээгч</td><td>Мэргэжил харгалзахгүй</td><td>1</td><td>1</td><td></td></tr> <tr> <td>Жолооч</td><td>Жолооч мэргэжилтэй</td><td>1</td><td>1</td><td></td></tr> <tr> <td colspan="5">Багц – 3, 4 шаардлагатай ажилтан</td></tr> <tr> <td>Түгээгч</td><td>Мэргэжил харгалзахгүй</td><td>1</td><td>1</td><td></td></tr> <tr> <td>Жолооч</td><td>Жолооч мэргэжилтэй</td><td>1</td><td>1</td><td></td></tr> </tbody> </table> <p>Дээрх хүснэгтэд заасан мэргэжлийн ажилчдын иргэний үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн үзлэг орсныг гэрчлэх дэвтэр зэрэг баримт бичгийг тендерт ирүүлнэ.</p>	Албан тушаал	Мэргэжил боловсрол	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо	НД-ийн дэвтэрийн дугаар	1,2-р багцад шаардлагатай мэргэжлийн ажилтан					Хүнсний технологич /гэрээгээр ажилладаг байж болно/	1	1	2		Түгээгч	Мэргэжил харгалзахгүй	1	1		Жолооч	Жолооч мэргэжилтэй	1	1		Багц – 3, 4 шаардлагатай ажилтан					Түгээгч	Мэргэжил харгалзахгүй	1	1		Жолооч	Жолооч мэргэжилтэй	1	1	
Албан тушаал	Мэргэжил боловсрол	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо	НД-ийн дэвтэрийн дугаар																																					
1,2-р багцад шаардлагатай мэргэжлийн ажилтан																																									
Хүнсний технологич /гэрээгээр ажилладаг байж болно/	1	1	2																																						
Түгээгч	Мэргэжил харгалзахгүй	1	1																																						
Жолооч	Жолооч мэргэжилтэй	1	1																																						
Багц – 3, 4 шаардлагатай ажилтан																																									
Түгээгч	Мэргэжил харгалзахгүй	1	1																																						
Жолооч	Жолооч мэргэжилтэй	1	1																																						
	<p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: Шаардлагатай:</p> <p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 1 жил</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th><th rowspan="2">Гэрээний нэр</th><th rowspan="2">Барааны нэр</th><th rowspan="2">Гэрээний үнэ /мян. төг/</th><th colspan="3">Захиалагчийн мэдээлэл</th></tr> <tr> <th>Нэр</th><th>Хаяг</th><th>Утасны дугаар</th></tr> </thead> <tbody> <tr> <td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table> <p>Дээрх мэдээллийн хамт өмнөх захиалагч байгууллагуудтай сүүлийн 1 жилд байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийн үр дүнгийн талаар өмнөх бүх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p>	№	Гэрээний нэр	Барааны нэр	Гэрээний үнэ /мян. төг/	Захиалагчийн мэдээлэл			Нэр	Хаяг	Утасны дугаар																														
№	Гэрээний нэр					Барааны нэр	Гэрээний үнэ /мян. төг/	Захиалагчийн мэдээлэл																																	
		Нэр	Хаяг	Утасны дугаар																																					
ТШЗ 16.6.5	<p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана:</p> <p>Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: Гэрээт ажилд ашиглах дурьдсан машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн үзүүлэлт, жагсаалтыг доорх хүснэгтэд зааснаар бэлтгэж, тэдгээрийн гэрчилгээний эхээс татсан хуулбарыг ирүүлнэ /машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь компанийн өөрийн эзэмшлийн эсхүл түрээсийн байж болох бөгөөд 2022 оны түрээсийн гэрээг ирүүлнэ/ Үүнд:</p>																																								

	<p>Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр, зориулалт</p> <p>Машин тоног төхөөрөмж багаж хэрэгслийн нэр, зориулалтыг бичнэ.</p>	Тоо хэмжээ	Улсын бүртгэлийн гэрчилгээ	Эзэмшдэг байгууллага, иргэний нэр	Чанар байдал, ашиглалтад орсон огноо
ТШЗ 16.6.6	Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: Шаардана Багц-01 ,багц -02, багц-03 багц -04 шаардлагатай /МУ-ын стандартад нийцсэн агуулах, хөргүүр байна. Агуулахын дүгнэлтийг холбогдох эрх бүхий байгууллагаар гаргуулж ирүүлнэ/				
ТШЗ 18.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх:Үгүй				
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ					
ТШЗ 21.5.3	ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:				
ТШЗ 22.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2025 оны 01 дугаар сарын 24-ний өдөр Цаг: 12 цаг 30 минут				
ТШЗ 24.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2025 оны 01 дугаар сарын 24 -ний өдөр Цаг: 13 цаг 00 минут Тендер нээх газрын хаяг: Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг, хүүхдийн 1-р цэцэрлэгийн 1 давхар				
ТШЗ 28.2	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: Ашиглахгүй				

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

<i>Багцын дугаар</i>	<i>Бараа болон холбогдох үйлчилгээний нэр</i>	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>
Бүх багцад хамааралтай		<ul style="list-style-type: none"> ➤ Эрүүл мэндийн сайдын А/74, А/113 тушаалын илчлэг нормонд тохирсон бүтээгдэхүүнүүд эсвэл энэхүү тендер шалгаруулалтын бусад багцын бараа бүтээгдэхүүнийг давхардуулан санал болгохыг хориглоно. ➤ Монгол улсад мөрдөгдаж буй хүнсний эрүүл ахуйн тухай хуулинд нийцсэн, чанар стандартын шаардлага хангасан байх
Багц-01	Мах махан бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> - Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх - Хүнсний шинэ бүтээгдэхүүн, хадгалалтын хэмийг баримтлах нөхцлийг бүрдүүлсэн байх - Гарал үүслийн бичигтэй
Багц-02	Сүү сүүн бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> - Гарал үүслийн бичиг - Мэргэжлийн хяналтын газрын нян судлалын шинжилгээ хийгдсэн байх. - Хадгалах хугацаа дуусаагүй, сав баглаа боодол бүрэн бүтэн, хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдаагүй.
Багц - 03	Хүнсний ногоо, жимс жимсгэнэ	<ul style="list-style-type: none"> - Гарал үүслийн бичиг - Мэргэжлийн хяналтын газрын нян судлалын шинжилгээ хийгдсэн байх. - Хадгалалтын горим алдагдаагүй, ялзарч, ургалт үүсээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй байх <ul style="list-style-type: none"> - Монгол орны хөрсөнд ургасан, зөөвөрлөлтийн горим алдагдаагүй, хэлбэр дүрс, өнгө үзэмжээ алдаагүй байх - Эх орны хөрсөнд ургасан. - Өвчлөл хөнөөлт шавьжаар гэмтээгүй, бүтэн, хуурай, хөгцрөөгүй, ургаагүй, зөөлрөөгүй, сортын хэлбэрээр дүрсээ хадгалсан байх. - Шалбарсан байх боловч махлаг эд нь хүрэнтэж зөөлрөөгүй, гол хэсэгт хөндий үүсээгүй байх.
Багц-04	Хүнсний бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> - Сав баглаа боодол бүрэн бүтэн, хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх - Хүнсний бүтээгдэхүүний хугацаа хэтрээгүй байх

Зөвхөн нэг үнэ ирүүлэх бөгөөд гэрээний хэрэгжилтийн хугацаанд үнэ тогтвортой байна.

Тухайн барааны зах зээлийн нэгж үнэ гэрээнд заасан үнээс 20 хувь түүнээс дээш хувиар буурсан тохиолдолд статистикийн судалгааг үндэслэн захиалагч, нийлүүлэгч харилцан тохиролцож барааны нэгж үнийг бууруулах өөрчлөлтийг хийнэ. Барааны үнэд үүнээс бусад өөрчлөлт хийхийг хориглож энэ заалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж, тун	ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа		
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (Эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)	
1	2	3	4	5	6	7	
1	[Барааны нэрийг бичих]	[Нэгжийн тоо ширхгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бичих. Жишээ нь: 2020.10.01-ээс 2020.10.14]	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]	
2							
3							
...							

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [тендерт оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээний маягт)-ын нөхцөлтэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 15.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээнээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 12.4 болон 15.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс ¹	Тоо хэмжээ	Хэмжи х нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ²
1										Тийм/Үгүй
2										
...										
							Тендерийн нийт үнэ			

Маягт 2 Барааны үнийн задаргаа

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:

¹ ТШЗ-ны 16.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.

² Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 3 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.8. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Хоног” гэж хуанлийн хоногийг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг

**хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар
Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс
томилогдсон этгээдийг;**

- 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно;
- 1.2.2. бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй;
- 1.2.3. зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана;
- 1.2.4. ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална;
- 1.2.5. гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсэн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

- 2.1. Нийлүүлэгч нь Гэрээ болон Бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад тэдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
- 2.3. ГЕН-ийн 1.4-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
- 2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг

гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

- | | |
|---------------------------|---|
| Бараа нийлүүлэх газар | 2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана. |
| Барааг хүлээлгэн өгөх | 2.6. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, тэмдэглэл үйлдэнэ.
2.7. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ. |
| Барааны гарал үүслийн улс | 1.8. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
2.9. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна. |
| Баглаа боодол | 2.10. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.
2.11. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд холбогдох хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. |
| Худалдааны нөхцөл | 2.12. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
2.13. Гэрээнд хэрэглэж байгаа Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг ГТН-д заана.
2.14. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр ГЕН-ийн 2.5-д заасан газарт хүргүүлэхнэ. |
| Барааг хүлээн авах | ГУРАВ. ЗАХИАЛАГЧ |
| Шалгалт, туршилт | 1.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. |

- | | |
|-------------------------------|---|
| | <p>3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p> <p>3.7. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8. Гэрээний үнэд тохируулга хийхгүй.</p> <p>3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>3.10. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.11. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.12. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.13. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |
| Гэрээний үнэ | |
| Төлбөр төлөх | |
| Захиалагчийн хүлээх
эрсдэл | <p>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</p> <p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна.</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p> |
| Даатгал | <p>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.</p> |
| Доголдол | <p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p> <p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p> <p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө</p> |

- зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
- 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
- 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- Чанарын баталгаа
- 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
- 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
- 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаа гарган баталгаажуулж болно.
- 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаа гаргасан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
- 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.
- 4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- Алданги
- 4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлэгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.

- | | |
|---|--|
| Оюуны өмчийн эрх зөрчих | 4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал | <p>4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.8-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг сунгаж болно.</p> |
| Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа | <p>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.8-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл | <p>ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ</p> <p>5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:</p> <p>5.1.1. нийлүүлэгч үүргээ гэрээнд заасан хугацаанд, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч Нийлүүлэгч нэмэлт хугацаанд үүрэг гүйцэтгээгүй;</p> <p>5.1.2. бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> |

- | | |
|--|---|
| <p>Гэрээнээс татгалзах,
гэрээг цуцлах мэдэгдэл</p> <p>Төлөөлөгч</p> <p>Нууцлал</p> <p>Мэдэгдэл</p> | <p>5.2. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.3. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p> <p>5.4. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.</p> <p style="text-align: center;">ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ</p> <p>6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажлын болон өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3. Гэрээг хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> <p>6.5. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтанд авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>6.6. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p> <p>1.7. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>1.8. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.7 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>1.9. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх, эсхүл шуудангаар нөгөө талын гэрээ Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>1.10. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> |
|--|---|

- 1.10.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 1.10.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор тэмдэглэлийг үндэслэн;
- 1.11. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 1.12. ГЕН-ийн 6.3-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- Маргаан шийдвэрлэх 1.13. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 1.14. Талууд зөвшилцөн шийдвэрлэж эс чадвал Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гэрээний үүргийн гүйцэтгэл болон гэрээг цуцалсан, гэрээнээс татгалзсантай холбоотой аливаа маргааныг Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1.	<p>Бараа нийлүүлэх хугацаа:</p> <p><i>Бараа нийлүүлэх хугацаа: [огноо бичих]</i></p> <p><i>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: [огноо бичих]</i></p> <p><i>[Нийлүүлэлтийн хуваарь байгаа бол түүнийг ишлэх]</i></p>
ГЕН 2.5.	<p>Бараа нийлүүлэх газар:</p> <p><i>[Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх газрын хаяг байршил гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй бичих.]</i></p>
ГЕН 2.6.	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <p><i>[Бараа хүлээлгэн өгөх нөхцөлийг тодорхой бичих]</i></p> <p>Жишээ нь:</p> <p>Бараанд холбогдох баримт бичиг: <i>[бараанд холбогдох ямар баримт бичгүүдийг хүлээлгэж өгөх талаар бичих]</i></p> <p>Угсралт, суурлуулах: <i>[ямар барааг юунд хэрхэн угсарч, суурьлуулах]</i> гэх мэт.</p>
ГЕН 2.10.	<p>Баглаа, боодол:</p> <p><i>[Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөл, шаардлагыг тодорхой бичих]</i></p> <p><i>[Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]</i></p> <p>Баглаа, боодлын шаардлага:</p>

	<p>Жишээ нь:</p> <p>[Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлсийг харгалзсан байна гэх мэт]</p>
ГЕН 2.13.	<p>Худалдааны нөхцөл:</p> <p>[Тендерийн баримт бичгийн ТӨХ-д заасан бол ТШЗ 18.6-д заасан Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хуулж бичих]</p>
ГЕН 3.9.	<p>Төлбөр төлөх хугацаа:</p> <p>Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр]</p> <p>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд, Төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]</p>
ГЕН 4.2.	<p>Даатгал:</p> <p>[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрлийг тодорхой бичих]</p>
ГЕН 4.10.	<p>Чанарын баталгаат хугацаа:</p> <p>[Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол Тендерийн баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих]</p>
ГЕН 4.11	<p>Чанарын баталгаа:</p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: [Чанарын баталгаа шаардана/ шаардахгүй]</p> <p>Чанарын баталгаа шаардах бол, Чанарын баталгааны дүн: [Гэрээний үнийн дүнгийн 5-10 хооронд сонгох]</p>
ГЕН 4.17.	<p>Нийлүүлэгчийн төлөх алданги:</p> <p>Алдангийн хувь: [хоногт 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</p>
ГЕН 4.18.	<p>Захиалагчийн төлөх алданги:</p> <p>Алдангийн хувь: [хоногт 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</p>

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Төндер шалгаруулалтын нэр] гэрээ
Дугаар № [Төндер шалгаруулалтын дугаар]

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчээс ирүүлсэн төндерийг хүлээн зөвшөөрч энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг нийлүүлэгч-ийн харилцахбанкны дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 2. Гэрээ баталгаажуулах маягт;
 3. Гэрээний тусгай нөхцөл;
 4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 5. Техникийн тодорхойлолт;
 6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх/-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх/-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА